



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/205

Булган сум

**Волейболын улсын аварга шалгаруулах  
тэмцээнд оролцох тамирчдад дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2025 оны А/377 дугаар захирамжаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Биеийн тамир, спортыг хөгжүүлэх, хүүхэд, залуучуудын дунд багийн спортыг дэмжих зорилгоор Баянхонгор аймагт зохион байгуулагдах U17 насны волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдын байр, хоолны зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР